

УВС АЙМГИЙН 2017 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ЭРҮҮ, ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2017.02.04

Улаангом сум

Нэг. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХИ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Увс аймгийн цагдаагийн газарт 2017 оны 01 сарын 01-ны өдрөөс 2017 оны 01 сарын 31-ны өдөр хүртэлх хугацаанд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 88, зөрчлийн шинжтэй 133, бусад -18 шийдээгүй үлдсэн-12 нийт- 251 гомдол, мэдээлэл хүлээн авсан. Өмнөх оны мөн үеэс +115 нэгжээр буюу 84,5 хувиар өссөн байна.

Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн гэмт хэргийн шинжтэй 88 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 нэгжээр буюу +83.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийн 44 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, 44 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай Прокурорын хяналтанд хүргүүлж шийдвэрлэсэн. Захиргааны зөрчлийн шинжтэй 133 гомдол мэдээлэл хүлээн авснаас 98 буюу 76.3 хувийг шийтгэврээр торгож, 2 буюу 1.5 хувийг баривчлах, 23 буюу 17.2 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч торгох шийтгэл ноогдуулан шийдвэрлэсэн.

Архидан согтуурч захиргааны зөрчил гаргасан 65 хүнийг саатуулсан нь 24 нэгжээр өссөн байна.

Торгуулийн хуудсаар, бэлэн бус торгуулиар 699 зөрчилд 12.524.000 төгрөгний торгууль, шийтгэврийн хуудсаар 128 зөрчилд 15.608.000 төгрөгний торгууль ногдуулсан.

Хоёр. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг: Аймгийн хэмжээнд **43** гэмт хэрэг бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс **27 хэргээр буюу 168.8 хувиар өссөн байна.**

- Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 82.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс +269.8 хувиар өссөн.

Хэргийг ангиллаар нь авч үзвэл: хөнгөн гэмт хэрэг-26, хүндэвтэр гэмт хэрэг-19, хүнд, онц хүнд гэмт хэрэг бүртгэгдээгүй.



Гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:


-25 хэрэг буюу 58.1 хувь нь бусад суманд

-18 хэрэг буюу 41.8 хувь нь Улаангом сумдын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн

2017 оны эхний 01 сарын байдлаар 43 хэрэг шалгаснаас 26 буюу 60.4 хувьд нь хэрэг бүртгэлт, 19 буюу 39.5 хувьд нь мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Хялбаршуулсан журмаар 19 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 хэргээр буюу 171.4 хувиар өссөн үзүүлэттэй байна.

Шалгасан хэргийг 2016 оны мөн үетэй харьцуулбал:



Гэмт хэргийн улмаас :

Иргэн, аж ахуй нэгж байгууллагад учирсан 68.000.000 төгрөгний хохиролын 26.200.000 төгрөгний хохиролыг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь нь 38.5 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад -20 хувиар буурсан. Иргэд аж ахуй нэгж байгууллагаас 17.900.000 төгрөгний хохирол битүүмжилж ажилласан.

Үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:

- Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг -5
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг-17
- Танхайрах гэмт хэрэг-1
- Иргэдийн өмчийн хулгай-5
- Малын хулгай -11
- бусдын эд хөрөнгө завших үрэгдүүлэх-1
- гээгдэл эд зүйл, мал ашиглах-2 тус тус бүртгэгдсэн байна.

Үйлдэгдсэн бүх хэргийн 16 буюу 37.2 хувь нь хулгайн хэрэг, хулгайн хэргийн 11 буюу 68.7 хувийг мал хулгайлах хэрэг эзэлж байгаа ба өмнөх оны

мөн үетэй харьцуулахад 8 хэргээр буюу +266.6 хувиар өссөн. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 5 байгаа нь өмнөх оноос 5 хэргээр буюу +100 хувь өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргүүдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 4 нэгжээр, хүүхэд оролцсон гэмт хэрэг 1 нэгжээр, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 10 нэгжээр, гэр орон сууц 7нэгжээр,*гэр бүлийн хүчирхийллийн* улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 3 нэгжээр тус тус өсч бүлэглэн оролцож үйлдсэн хэрэг 1 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН: МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

М.ОДХҮҮ